



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 21/01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт,
Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон
Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн
дээр 2021 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
шийдвэр, Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг
хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 21/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Айтүүлс” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Ердийн гишүүд:

1. Г.Хатанболд
2. А.Баттамир
3. Н.Улаанхүү
4. Б.Эрдэнэжаргал
5. Б.Тамир
6. Б.Амгаланбаатар

Хараат бус гишүүд:

1. З.Мягмарсүрэн
2. Г.Гантуяа
3. Н.Жавхлан

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 21/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдийн цалин,
урамшууллын төсвийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт,
“Айтүүлс” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны
болон гишүүдийн цалин урамшууллыг 46,607,360 /дөчин зургаан сая зургаан зуун
долоог мянга гурван зуун жар/ төгрөгөөр баталсугай.
2. Төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 21/04

Улаанбаатар хот

Зээлийн гэрээ байгуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, 92 дугаар зүйл 92.3 дахь хэсэг, Айтүүлс ХК-ийн 2021 оны 04 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн 2021 оны Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд “Ай Си Ти Групп” ХК-аас 1,200,000,000 /нэг тэрбум хоёр зуун сая/ төгрөгийн хөрөнгө оруулалтыг зээлийн гэрээ байгуулан 4 жилийн хугацаатай, барьцаагүй, сарын 2 хувийн хүүтэй, 6 сар тутам хүү төлж, үндсэн зээлийг хугацааны эцэст төлөх нөхцөлтэйгөөр авахыг Гүйцэтгэх захирал Б.Тамирт зөвшөөрсүгэй.
2. Тус зээлийн гэрээг Иргэний хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд нийцүүлэн байгуулахыг Гүйцэтгэх захирал Б.Тамирт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД